



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/342

Булган сум

**Нийлүүлэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан аймгийн ЗДТГ-ын хурлын танхимын тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчээр шалгарсан “Майтеч” ХХК-тай 32,882,000 (гучин хоёр сая найман зуун наян хоёр мянга) төгрөгөөр, гэрээ байгуулж холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т олгосугай.

2.Гэрээнд заасан тоног төхөөрөмжийг холбогдох хууль, журам, стандартын дагуу хүлээлгэн өгөхийг “Майтеч” ХХК-ийн захирал (Б.Гантуяа)-д үүрэг болгосугай.

3.Тус барааны санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010834